

**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2026 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЖАГСААЛТАД БАТЛАГДСАН ЗАРИМ АЖЛЫН ГЭРЭЭГ ШУУД БАЙГУУЛАХ ТУХАЙД
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 03 дугаар сарын 03

Улаанбаатар хот

1. Хяналт шалгалтын зорилго:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/37 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, гүйцэтгэгчтэй хугацаа сунгах, гэрээ байгуулах эсэх талаар тухай бүр дүгнэлт гаргах ажлын хэсэг”-ийн 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэлээ.

2. Хяналт шалгалтад хамрагдсан асуудал:

Санхүү, хөрөнгө оруулалтын газраас дараах 5 төсөл, арга хэмжээний Улсын 2026 оны хөрөнгө оруулалтын төсөвт батлагдсан дүн буюу нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний дүнгийн 15 хувиас хэтрэхгүй тул гэрээг шууд байгуулах аргыг ашиглан гэрээ байгуулах саналыг ажлын хэсгийн хуралд хэлэлцүүлсэн болно.

Ажлын хэсгийн хурлаас эдгээр 5 ажлын нэмэлт ажлын өртөг анхны гэрээний дүнтэй харьцуулахад хуульд заасан хувьд нийцэж байгаа эсэхэд дотоод аудитын дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсэн болно.

Улсын төсвийн 2026 оны хөрөнгө оруулалтад батлагдсан нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн дүнгийн 15 хувь дотор багтсан гэж үзсэн 5 ажлын мэдээлэл

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг			2026 онд санхүүжих дүн
				Анхны	Сүүлийн	2026 он	
	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД					69,756.6	4,365.1
	Соёл I. Барилга байгууламж					43,903.0	2,421.5
1	Төв номын сангийн барилга /Булган, Булган сум/	2024	2026	3,130.2	2,945.8	3,124.0	183.8
2	Соёл, спорт цогцолборын барилга /Хөвсгөл, Мөрөн сум/	2019	2026	6,000.00	10,892.7	11,504.9	612.3
3	Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей, лаборатори /Төв, Зуунмод сум/	2021	2027	18,000.0	26,177.8	29,274.1	1,625.4
	Спорт I. Барилга байгууламж					25,853.6	1,943.6
4	Спортын ордны барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	2021	2026	7,900.0	10,312.5	11,120.7	808.2
5	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2010	2026	2,561.3	13,597.6	14,732.9	1,135.4

Хууль эрх зүйн зохицуулалт:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйл 36.1-д Захиалагч дараах нөхцөлд нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэж болно буюу “36.1.4. нээлттэй тендер шалгаруулалтын

аргаар худалдан авсан ажлын нэмэлт ажлын өртөг анхны гэрээний үнийн 15 хувиас хэтрэхгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол” гэж заасан байна.

3. Хяналт шалгалтаар тогтоогдсон бодит нөхцөл байдал (илрүүлсэн зөрчил дутагдал, түүний шалтгаан нөхцөл, гарч болзошгүй буюу гарсан хохирол)

3.1 Булган аймгийн Булган сумын нутагт баригдсан Төв номын сангийн барилга

Соёлын яам /хуучин нэрээр/ -наас зарласан нээлттэй тендер шалгаруулалтад Зууны сод хийц ХХК шалгарч 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Соёлын яам /хуучин нэрээр/ буюу захиалагч байгууллагатай 2,954,777,588 төгрөгийн үнийн дүн бүхий СОЯ/20240101026 дугаар гэрээг байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад батлагдсан Булган аймгийн Төв номын сангийн барилга /УТ2403401086/ -ын нэмэлт ажлын төсөв 183.8 сая төгрөг нь гүйцэтгэгч Зууны сод хийц ХХК-ны анхны гэрээний дүнтэй харьцуулахад 6.2 хувьтай тэнцэж байгаа тул ТБОНӨХБАҮХАТ хуулийн 36.1.4 дэх заалтын дагуу нэмэлт ажлын гэрээг шууд байгуулах эрх зүйн үндэслэлтэй нийцэж байна.

3.2 Хөвсгөл аймгийн Мөрөн сумын нутагт баригдаж буй Соёл, спорт цогцолборын барилга

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зарласан нээлттэй тендер шалгаруулалтад Суут гэр ХХК шалгарч 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдөр БСШУСЯ буюу захиалагч байгууллагатай 5,820,444,449 төгрөгийн үнийн дүн бүхий ТӨБЗГ-2019/ХИ.3.1.14 гэсэн дугаартай гэрээг анх байгуулсан байна.

Суут гэр ХХК-тай байгуулсан анхны гэрээнд нэмэлт ажлын төсөв баталж, өөрчлөлт оруулсан талаарх судалгааны дүн

Гэрээний төрөл	Гэрээний			Өмнөх гэрээг		Захиалагч
	Дугаар, огноо	Хугацаа	Мөнгөн дүн /сая төгрөг/	Нэмэгдүүлсэн дүн /сая төгрөг/	хувь	
Эхний гэрээ	ТӨБЗГ-2019/ХИ.3.1.14 2019.08.28	2021.08.26 2023.08.25	5,820.4			БСШУСЯ
Нэмэлт гэрээ	ТӨБЗГ-2019/ХИ.3.1.14+1 2021.04.01					-
	ТӨБЗГ-2019/ХИ.3.1.14+2 2022.04.25	2022.04.25	9,614.1	3,793.7	65.2%	-
	ТӨБЗГ-2019/ХИ.3.1.14+3 2023.02.06	2023.12.25	10,892.7	1,278.5	22.0%	БТСУХ
	УТ2003100016 2024.01.26					СоЯ
	УТ2003100016+1 2025.01.29	2025.08.30				ССАЖЗЯ
УТ2003100016+2 2025.09.30	2021.08.26 2025.12.31					

одоо байгуулах гэрээ		11,505.0	612.3	10.5%	
Дүн			5,684.5	97.7%	

Суут гэр ХХК-ны байгуулсан гэрээнд нийт 6 удаа нэмэлт өөрчлөлт оруулж гэрээний дүн, хугацааг өөрчилсөн байна.

Гэрээ анх байгуулсан дүнг Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 368/2021 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан 3,793.4 сая төгрөгийн дүнгээр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Мөн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон 2022 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 88-174/2022 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан 1,278.5 сая төгрөгийн төсвийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь заалтыг үндэслэн гэрээний дүнд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад батлагдсан Хөвсгөл аймгийн Соёл, спортын цогцолборын барилга /УТ2003100016/ -ын нэмэлт ажлын төсөв 612.3 сая төгрөг нь гүйцэтгэгч Суут гэр ХХК-ны анхны гэрээний дүнтэй харьцуулахад 10.5 хувьтай тэнцэж байгаа тул ТБОНӨХБАҮХАТ хуулийн 36.1.4 дэх заалтын дагуу нэмэлт ажлын гэрээг шууд байгуулах эрх зүйн үндэслэлтэй нийцэж байна.

3.3 Төв аймгийн Зуунмод сумын нутагт баригдаж буй Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей, лабораторийн барилга

Төрийн худалдан авах ажиллагааны газраас зарласан нээлттэй тендер шалгаруулалтад Тэргүүн чансаа ХХК шалгарч 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдөр Соёлын яам /хуучин нэрээр/ буюу захиалагч байгууллагатай 17,6650,836,375 төгрөгийн үнийн дүн бүхий СОЯ/20210311 дугаар гэрээг байгуулсан байна.

Барилгын ажилд нэмэлт ажлын хөрөнгө тухайн жилийн улсын хөрөнгө оруулалтын төсөвт батлагдсантай холбогдуулан 2022, 2023 онд 2 удаа гэрээний дүнг нэмэгдүүлсэн өөрчлөлт хийж гэрээг байгуулсан. Энэхүү өөрчлөлтийг хийхдээ ТБОНӨХБАҮХАТ хуулийн 36.1.4 дэх заалтыг зөрчин 15 хувиас хэтрүүлсэн дүнгээр буюу 2022 онд 25.2 хувийн, 2023 онд 23.1 хувийн нэмэлт ажлын төсөв батлагдсан байхад худалдан авах ажиллагааг зарлахгүйгээр гэрээг шууд байгуулсан зөрчил гаргасан байна.

Тэргүүн чансаа ХХК-тай байгуулсан анхны гэрээнд нэмэлт ажлын төсөв баталж, өөрчлөлт оруулсан талаарх судалгааны дүн

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил		Гэрээний			Өмнөх гэрээг	
		Дугаар	Хугацаа	Мөнгөн дүн	Нэмэгдүүлсэн дүн	хувь
Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей,	Эхний гэрээ	СОЯ/20210311	2021.08.26 2023.08.25	17,650.8		
	2 дахь гэрээ	СОЯ/20210311 +1		22,106.0	4,455.2	25.2%
	3 дахь гэрээ	СОЯ/20210311 +2	2021.08.26 2024.10.31	26,177.7	4,071.7	23.1%

лаборатори /Төв, Зуунмод сум/	одоо байгуулах гэрээ			27,803.1	1,625.4	9.2%
Дүн					10,152.2	57.5%

Энэ онд буюу Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад батлагдсан Музей, лабораторийн барилга /УТ2003400788/-ын нэмэлт ажлын төсөв 1,625.4 сая төгрөгийг гүйцэтгэгч Тэргүүн чансаа ХХК-ны анхны гэрээний дүнтэй харьцуулахад 9.2 хувьтай тэнцэж байгаа боловч өнгөрсөн хугацаанд анхны гэрээний дүнг 8,526.8 сая төгрөгөөр буюу 48.3 хувиар нэмэгдүүлсэн тул ТБОНӨХБАҮХАТ хуулийн 36.1.4 дэх заалтыг үндэслэн нэмэлт ажлын гэрээ байгуулах эрх зүйн үндэслэлгүй байна.

Иймд энэ ажлын нэмэлт төсвийн дүнгээр худалдан авах ажиллагааг зарлаж сонгон шалгаруулалтыг явуулах шаардлагатай гэж дүгнэв.

3.4 Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт баригдаж буй Спортын ордны барилга

Төрийн худалдан авах ажиллагааны газраас зарласан нээлттэй тендер шалгаруулалтад Бигмонголиа билдинг ХХК шалгарч 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Биеийн тамир, спортын улсын хороо буюу захиалагч байгууллагатай 7,956,414,774 төгрөгийн үнийн дүн бүхий БТСУХ/202102002 дугаар гэрээг байгуулсан байна. Өнгөрсөн хугацаанд энэ ажлын гэрээнд 6 удаа өөрчлөлт оруулахдаа 1 удаа нэмэлтийн ажлын төсвийг нэмсэн, 5 удаа гэрээний хугацааг сунгаж нэмэлт гэрээ байгуулсан байна.

Бигмонголиа билдинг ХХК-тай байгуулсан анхны гэрээнд нэмэлт ажлын төсөв баталж, гэрээний хугацаанд өөрчлөлт оруулсан талаарх судалгааны дүн

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Гэрээний			Өмнөх гэрээг		Захиалагч	
	Дугаар	Хугацаа	Мөнгөн дүн	Нэмэг дүүлсэн дүн	хувь		
Спортын ордны барилга /Архангай, Эрдэнэ булган сум/	Эхний гэрээ	БТСУХ/202102002 2021.07.09	2021.08.26 2023.08.25	7,956.4			
	Нэмэлт гэрээ	БТСУХ/202102002+1					БТСУХ
		БТСУХ/202102002+2 2023.01.17	2021.07.09 2023.10.31	10,208.9	2,252.5	28.3%	
		БТСУХ/202102002+3 2023.10.24	2021.07.09 2023.12.31				
		БТСУХ/202102002+4 2024.01.25	2021.07.09 2024.09.30				
		БТСУХ/202102002+5 2024.12.26	2021.07.09 2024.12.31				
	БТСУХ/202102002+6 2025.04.15	2021.07.09 2025.06.30				ССАЖЗЯ	
одоо байгуулах гэрээ			11,017.1	808.2	10.2%		
Дүн				3,060.7	38.5%		

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 88-113/2022 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан 2,612.5 сая төгрөгийн төсвийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь заалтыг үндэслэн гэрээний дүнд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Энэ онд буюу Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад батлагдсан Спортын ордны барилга /УТ200300002/-ын нэмэлт ажлын төсөв 808.2 сая төгрөгийг гүйцэтгэгч Бигмонголиа билдинг ХХК-ны анхны гэрээний дүнтэй харьцуулахад 10.2 хувьтай тэнцэж тул ТБОНӨХБАҮХАТ хуулийн 36.1.4 дэх заалтын дагуу нэмэлт ажлын гэрээг шууд байгуулах эрх зүйн үндэслэлтэй нийцэж байна.

3.5 Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт баригдаж буй Дүүргийн спорт цогцолборын барилга

Төрийн худалдан авах ажиллагааны газраас зарласан нээлттэй тендер шалгаруулалтад Атимострейд ХХК шалгарч 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр БСШУСЯ буюу захиалагч байгууллагатай 11,014,800,000 төгрөгийн үнийн дүн бүхий БСШУСЯ/3/03-ХААГ-14/001 дүгээр гэрээг анх байгуулсан байна.

Атимострейд ХХК-тай байгуулсан анхны гэрээнд нэмэлт ажлын төсөв баталж, гэрээний хугацаанд өөрчлөлт оруулсан талаарх судалгааны дүн

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил		Гэрээний			Өмнөх гэрээг		Захиалагч
		Дугаар	Хугацаа	Мөнгөн дүн	нэмэгдүүлсэн дүн	хувь	
Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	Эхний гэрээ	БСШУСЯ/3/03-ХААГ-14/001 2018.03.14		11,014.8			БСШУСЯ
	Нэмэлт гэрээ	УТ2103100791 2023.12.25	2021.05.13 2024.12.25	13,597.6	2,582.8	23.4%	БТСУХ
		УТ2103100371+1 2025.12.12	2021.05.13 2024.12.30				
	одоо байгуулах гэрээ					1,135.4	10.3%
Дүн					3,718.2	33.8%	

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 397/2019 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан 2,582.8 сая төгрөгийн төсвийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь заалтыг үндэслэн гэрээний дүнд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Энэ онд буюу Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад батлагдсан Дүүргийн спортын цогцолборын барилга /УТ2103100791/-ын нэмэлт ажлын төсөв 1,135.4 сая төгрөгийг гүйцэтгэгч Атимострейд ХХК-ны анхны гэрээний дүнтэй харьцуулахад 10.3 хувьтай тэнцэж байгаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 36.1.4 дэх заалтын дагуу нэмэлт ажлын гэрээг шууд байгуулах эрх зүйн үндэслэлтэй нийцэж байна.

4. Дүгнэлт

Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад батлагдсан 5 барилгын ажилд батлагдсан нэмэлт ажлын төсөв нь уг ажлыг гүйцэтгэгч компанийн нээлттэй тендер шалгаруулалтаар шалгарч байгуулсан анхны гэрээний дүнгийн 15 хувиас хэтрэхгүй нөхцөлд буюу ТБОНӨХБАҮХАТ хуулийн 36.1.4 дэх заалтын дагуу гэрээг шууд байгуулах нөхцөл шаардлагыг хангаж буй эсэхэд дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэхэд Булган аймгийн Төв номын сангийн барилга, Хөвсгөл аймгийн Соёл, спорт цогцолборын барилга, Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Спорт ордны барилга, Баянзүрх дүүргийн спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчтэй гэрээг шууд байгуулах эрх зүйн үндэслэлийн шаардлагыг хангасан байна.

5. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж

Төв аймгийн Зуунмод суманд байршилтай Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей, лабораторийн барилгын 2026 онд батлагдсан нэмэлт ажлын төсвийн дүнгээр худалдан авах ажиллагааг зарлан сонгон шалгаруулалтыг явуулж, шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

---оОо---